

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН АЛТАЙН ХЯЗГААР

*Б.Нямдорж**

ХҮШ зууны дунд үеэс Алтай хавийн газар нутаг нь Манж Чин улсын эрхшээлд орж, Улиастайн жанжины харьяан дахь Ховдын хувийн сайдад захирагдан, нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд Ховдын хязгаарт хамрагдах болжээ. Манж нар баруун монголыг байлдан дагуулах үед түүний эрхшээлд орсон торгууд, хошууд, урианхай нарыг Алтай хавийн нутагт суулгажээ. Мөн Шинжааны бүрэлдхүүнд байсан казахууд 1860-аад оноос Алтайд олноор нүүж ирж амьдран суух болжээ. Үүний улмаас монгол казахуудын дунд газар нутаг булаалдах зөрчил тогтмол гарах болжээ. Мөн уйгур зэрэг бусад угсаатнууд байсны дээр эхэн үедээ цөөн хятадууд байснаа хожим Шинэ засгийн бодлогын жилүүдэд тарианы болон цэргийн олон хятад цэргүүдийг нүүлгэн суулгаж суурьшуулснаар олширчээ. Мөн оросууд Алтай хавийн нутагт нөлөөгөө тогтоохыг эртнээс сонирхох болж, улмаар оросын харьяат иргэд, худалдаачид олноор орж ирж суурьших болов. XX зууны эхэн үед Алтайн хязгаарт зуу гаруй оросууд амьдарч байжээ. Энэ үеэс Алтай хавийн нутаг дэвсгэрт өөр өөр угсаа гарал, соёл бүхий олон үндэстэн оршин суух болжээ.

Манж Чин улс Алтайн хязгаарыг Ховдын хязгаараас тусгаарлах гэж оролдсон нь

XX зууны эхэн үеэс манж нар Шинэ засгийн бодлогын хүрээнд Алтай хавийн газар нутгийг Ховдын хязгаараас салган тусгаарлах бодлого барих болжээ.

Энэ дагуу 1904 он [Бадаргуулт төрийн 30-р он]-д Манж Чин улсын засгаас Чэндугийн жанжин Чан Гэнг Алтайн газар орны байдалтай танилцуулахаар томилон явуулжээ. Тэрбээр газар орны байдалтай танилцсаны үндсэн дээр Манжийн хаанд айлтгал бичиж “Алтайн уул бол баруун хойд хязгаарын чухал газар орон бөгөөд дундад, гадаадын сэргийлэлийн орон болох тул ноён суулгаж хамааруулах хэрэгтэй” [13.357] гээд Ховдын хувийн сайдыг Эрчист, Ховдын хэрэг шийтгэх сайдыг Алтай буюу Буурал тохойд шилжүүлэн суулгах саналыг дэвшүүлжээ. Айлтгалыг манжийн хаан хүлээн авч, Ховдын хувийн сайд Рүй Шүнтэй уг асуудлаар нухацтай ярилцахыг зааварлажээ.

*Б.Нямдорж - МУИС-ийн Ховд дахь салбар сургууль. Нийгмийн ухааны тэнхим. багш, докторант

Мөн тэр үед Ховдын хуувийн сайд Рүй Шүн Алтайн газар орны асуудлаар манжийн хаанд айлтгасан мэдүүлэгт “Алтайн газар орныг бас л Ховдын хуувийн сайд холоос захирахад дөхөм биш.Цаашилбаас чадал хүрэхгүй байж мэднэ.Ховдыг захирах газар чухал биш.Нэгэнт ар зам болсон тул олон ноён тавьсаны хэрэггүй.Хуувийн сайдыг Ховдод суулгаж, харин эрхийг нь нэмж ихэтгэвэл бүгдийг ерөнхийлэн захирч чадах бөгөөд ер бусын байдлыг аргацааж чадна.Буурал тохой бол завсарын газар болохоор нэгэн ноён нэмэн тавьж, цэрэг суулган хамааруулбал зүг бүхэндээ зам нэвтэрч, нэг цогц болон нэгдэж чадна” [13. 358]гэж Ховдын хязгаар дахь засаг захиргааг шинэчлэх талаар өөрийн саналыг таниулжээ.

1907 оны I сарын 7-ны өдөр [Бадаргуулт төрийн 32-р оны 12 сарын 25] манжийн хаанаас зарлиг гарч, уг зарлигтаа “...Шинэ торгуудын 2 хошуу, хошуудын нэг хошуу, Алтайн урианхайн 7 хошуу, энэхүү бүгд 10 хошуу ба Чэнгистэйгээс баруунаа бүхий 8 харуул хийгээд Бүрэн тохойн тариалангийн газар хийгээд хасгийн нэг аймаг зэргийг цөм мөн оноос эхлэн Алтайн хэрэг шийтгэгч сайд Ши Хэн дор захируулбаас зохимой...” [21.156] гэжээ.

Манжийн хааны уг зарлиг шийдвэрийг Ховдын хуувийн сайд хүлээн аваад зарлигийн дагуу Ховдын хуувийн сайдын газраас Бадаргуулт төрийн 33-р оны 2 сард Ховд, Алтайн уулын 2 газар захыг хуваан захирах тушаалыг Ховдын хязгаарын Дөрвөдийн баруун гарын чуулган дарга ван Содномжамцойд болон Алтайн урианхай, торгууд, хошуудын хошуу ноёдод мэдүүлжээ.

Уг бичигт “...Ховдын харьяат захирсан баруун этгээдээс Алтай шань уулын газар ойр урианхайн зүүн гарын сул амбаны нэгэн хошуу, мээриний зангийн нэгэн хошуу, үхэри да-гийн 2 хошуу, баруун гарын сул амбаны нэг хошуу, үхэри-дагийн 2 хошуу, шинэ торгуудын жүн вангийн нэг хошуу, бэйсийн нэг хошуу, хошуудын засаг тайжийн нэг хошуу бүгд гурван аймаг, 10 хошууг боол Ши дор дагуулан хувааж, ойрыг үзэж захируулья, Хасаг ардыг шийтгэн суулгахад тус болгоё, түүний Чэнгистэйн зэрэг баруун 8 харуул үнэхээрийн Алтай шан уулын захад ойр дагалдагагаар басхүү Бортохойн тарианы газар цөм урианхайн нутаг дор буй.Чингэж зүй нь хамтаар Алтай шан ууланд дагуулан захируулья...Ховдод ойр Дөрвөдийн зүүн гарын Далай ханы харьяат 12 хошуу, баруун гарын чин вангийн харьяат 4 хошуу, захчины гүнгийн нэг хошуу, бүгдийн даргын нэг хошуу, мянгадын бүгдийн даргын нэг хошуу, өөлдийн бүгдийн даргын нэг хошуу, бүгд

дөрвөн аймаг, 20 хошууг боол Лиен уг хэвээр захируулья... “[1.5] гэж тушаан илгээжээ.

Энэ дагуу 1907 онд Ховдын Буянтад сууж байсан 2 амбан сайдын нэгийг Алтайн цаад Шар сүмд суулгаж, амбанаар нь хятад түшмэд Ши Хэнг тохоож, захиргааг нь байгуулав. Түүний харьяанд Ховдын хязгаарын баруун хэсгээс урианхайн 7 хошуу, хошуудын нэг хошуу, шинэ торгуудын 2 хошууг Өрөнгийн голын адгийн болон Бүрэн тохойн сангийн тариалангийн газрыг таслан захируулж, мөн Алтайн ар өврөөр шилжин ирж суурьшиж байсан хасагуудтай нийлүүлж, эл шинэ засаг захиргааг “Алтайн хязгаар” хэмээн нэрлэжээ. Энэ хязгаар нь хуучин хэвээр Хүрээний сайд, Улиастайн жанжинд захирагдах болжээ.

Ховдын хуулийн сайдын газраас Алтайн хязгаарын ноёд түшмэдийн орон тоо, цалин пүнлүүг “Урианхайн мэйрэн занги нэг, жил бүр үзвээс зохих пүнлүүний мөнгө 77 лан 5 цэн, сул амбан хоёр, үхэри-да 4, жил бүр түшмэл бүр үзвээс зохих пүнлүүний мөнгө 65 лан бүгд 7 түшмэл болбоос нэг жилд үзвээс зохих пүнлүүний мөнгө 467 лан 5 цэн “[1.6] байхаар тогтоож, Ховдын хуувийн сайдын газраас тавин өгч байхаар болжээ.

Энэ үеэс хойш Ховд, Алтайн хязгаарын хошуудын ноёдын хэргэм зэрэг залгамжлуулах, түшмэлийн оронд тавих зэрэг олон зүйлийн хэрэг зүй жич нутгийн доторх элдэв хүний амь, хулгайн зэрэг хэргийг тус тусдаа өөр өөрийн сайдын газарт мэдүүлэн хянан шийдвэрлэж байхаар болжээ.

Ховд Алтайн хязгаарын хооронд хилийн нарийн зааг тогтоогоогүй бөгөөд ерөнхий хилийн зааг нь Алтайн Зэсийн даваанаас Ачит нуурын баруун талаар Ховд гол хүрч уруудан Цаст уул, Мөнххайрхан уулын баруун талаар Булган голыг уруудаж, Хотон овоо, Цагаан түнгэ, Олон булгаар Үзүүр огчинд хүрч байжээ.[19.30]

Ийнхүү Алтайн хязгаарын газар нутагт Алтайн гол нуруунаас өмнө Шар сүм, Буурал тохой, Чингэл, Цагаан гол, Хар Эрчис, Өлөнгөр нуур зэрэг нутаг хамрагдах болов.

Алтайн хязгаарыг ийн тусгаарлах болсон нь нэг талаар Алтайн нурууны 2 талд байгаа олон хошуудыг нэгтгэн захирах явдалд байгаль цаг улиралын бэрхшээл байсантай холбогдоно. Нөгөө талаар Ховдын хуувийн сайдын дэргэд хэрэг шийтгэх сайдыг хавсаруулан суулгасан нь засаг захиргааны аливаа асуудлыг шийдвэрлэхэд санал зөрөлдөх, элдэв зүйлийн будилаан гарах нөхцлийг бүрдүүлж байсан явдал нөлөөлсөн байж болох боловч үнэн хэрэгтээ өөр нэгэн учир байжээ.

Харин энэ арга хэмжээний цаад шалтгаан нь XX зууны эхэн үеийн монголын гадаад дотоод улс төрийн нөхцөл байдлаас шууд урган гарчээ. Тэр үед манж-хятадын эсрэг монголын ард түмний ҮЭЧХ шинэ шатанд гарч, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэдний тэмцэл бүх үндэстнийг хамарч эрс шийдэмгий шинжийг олсон түүхэн эгзэгтэй энэ үед манж нарын зүгээс монголыг бүрэн эрхшээлдээ авч үлдэж чадахгүй тохиолдолд зах хязгаар газар нутгийг нь хэсэгчилэн хувааж тусгаарлан, улмаар өөртөө нэгтгэх гэсэн ноцтой бодлогын илрэл юм.

Мөн тэр үед тэр газар орныг сонирхох Оросын хаант улсын сонирхол нь идэвхжиж, улс төр эдийн засгийн нөлөө нь хүчтэй бэхжсэний дээр энэ хязгаарт керей хасгийн айлууд орж ирж зөрчил тэмцэл үүсгэх болсон зэрэг нь Ховдын хязгаарт нөлөөгөө сулруулахгүй байх, засаг захиргааг улам чангатган бататгахад чиглэгдсэн дээрх арга хэмжээг авахад хүргэжээ. Энэ бүхнээс үзэхэл Ховдын хязгаараас Алтайн хязгаарыг тусгаарласны цаад мөн чанар, шалтгаан нь манж хятадууд энэ чухал зурвас бүс нутгийг ямар ч болов алдахгүй байх яваандаа Ар монголоос таслан Шинжаанд нийлүүлэх хэтийн зорилгыг агуулж байсанд оршино.[8.45]

Энэ арга хэмжээ нь Манж Чин улсын хувьд энэ хязгаар нутагт өөрийн эрх ашиг, ноёрхолыг хамгаалж улам бэхжүүлэх, гадны нөлөөг хязгаарлах, засаг захиргааг чангатган бататгахад чухал ач тустай байжээ.

Тийнхүү тэр үеэс Ховдын хязгаар дахь олон монгол хошуудын зарим нь Алтайд, зарим нь Ховдод хоёр хуваагдан захирагдах болж, Ховдын хязгаар нь дөрвөдийн зүүн гарын 12 хошуу, мөн баруун гарын 4 хошуу, захчины 2 хошуу, мянгад өөлдийн тус бүр нэг хошуу бүгд 20 хошуутай үлджээ.

Гэвч энэ шийдвэрийг Алтайн хязгаарын хошууд эсэргүүцэж хэрэг дээрээ төдийлөн хэрэгжиж чадаагүй байна. Алтайн цаад этгээдэд нутагтай хошуудыг Шар сүмд харьяалуулан захируулсан хэдий ч Алтайн наад биеэр сууж байсан урианхайчуудын хувьд уг зарлигийг хүлээн дагасангүй, уг арга хэмжээг цаг үргэлж эсэргүүцээр хуучин хэвээр суусаар байв. Энэ байдал үргэлжилсээр 1911 оны ҮЭЧХ-тэй золгожээ.

Алтайн хязгаарын хошууд Монгол улсад дагаар орсон нь

1911 оны 12-р сарын 29-нд Олноо Өргөгдсөн Монгол улсыг байгуулж, монгол улсын тусгаар тогтнолыг дахин сэргээснийг тунхаглан зарлажээ.

Хүрээн дэх үйл явдлыг сонссон баруун хязгаарын олон ястан монголчууд тэр дундаа Алтайн хязгаарын монголчууд Богд Жибзундамба хааны тулгар төрд дуртайяа дагаж захирагдахаа илэрхийлсэн “Хүсэн батлах бичиг”-ээ бүгдээр ирүүлэн Монгол улсад дагаар оржээ. 1912 оны 6-р сарын 28-нд Алтайн урианхайн баруун гарын бүгдийн дарга Балдандоржийн харьяат хошуу, хавсран захирсан дарга Гомбожав, Ядамжав нарын хошуудын хамт Монгол улсад дагаар орохоо илэрхийлсэн хүсэн батлах бичгээ ирүүлжээ.[ҮТА.ФА-141.Д-1.ХН.-5] Мөн Алтайн урианхайн зүүн гарын сайд гүн Эрхшуну, харьяат захирах бүгдийн дарга Төрбат, Сандуйжав нар “Богд эзэн гэгээн таны соёл дор багтаж сүслэн дагасугай” хэмээх хүсэн батлах бичгээ 1912 оны 7-р сард өргөв.Шинэ торгуудын баруун гарыг захирах чин сэтгэлт шинэ торгууд аймгийн чуулганы дарга жүн ван Мишигдонров харьяат олны хамт Монгол улсад дагаар орохоо илэрхийлсэн хүсэн батлах бичгээ 1912 оны 7-р сарын 20-нд ирүүлэв. Шинэ торгуудын зүүн гарыг захирах чин сэтгэлт шинэ торгууд аймгийн чуулганы дэд дарга Магсаржав харьяат олноо Монгол улсад эргүүлж нийлүүлэх гэсэн өргөдлөө 1912 оны 7-р сарын 16-нд ирүүлжээ.Мөн 1912 оны 6-р сарын 29-нд хошуудын засаг тэргүүн зэрэг тайж Дамдинцэдэн хошуудын хамт Монгол улсад дагаар орохоо илэрхийлжээ. [ҮТА.ФА-141.Д-1.ХН-5]

Богдын засгийн газар эдгээр хүсэн батлах бичгийг хүлээн авч хариу бичигтээ “Богд эзний тулгар төрийг дагаар орсугай хэмээсэн нь үнэхээрийн журмыг зузаатгасан сайшаалтай бодлого” хэмээн сайшааж, нэр бүхий ван, бэйс, засаг бүгдийн дарга нарт хишиг хүртээж, хэргэм зэрэг шагнажээ.

Ийнхүү Ар монголд гарсан Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг Алтайн хязгаарын монголчууд талархан хүлээн авч, хязгаарын хошууд бүгд Олноо өргөгдсөн Монгол улсад дуртайяа дагаар орж захирагдахаа илэрхийлэхийн хамт хошуу ноёдоос Монгол улсын засгийн газарт хандан язгуураас мах цус барилдаж нэгэн дор цуг хамт аж төрсөөр ирсэн Алтайн хязгаарын ард олныг аврал өршөөлдөө багтаан өмгөөлөн хамгаалж, харь хятадын дарангуйлалаас нутаг орон хүн ардыг чөлөөлөн нэгтгэж, бүрэн бүтэн болгож, асран туслахыг хүсэх болжээ.

Дундад Иргэн улсаас Алтайн хязгаарт бэхжихийн төлөө

ТЭМЦСЭН НЬ

Ийнхүү нэгэнт монголд ҮЭЧХ ялж , монголчууд тусгаар тогтнолоо олж аван шинэ тулгар тогтсон Олноо өргөгдсөн Монгол улсын төрд монголчууд бүгдээр дагаар орох болсон нөхцөлд хятадууд

монголын газар нутгаас зарим хэсгийг нь таслан авахыг дахин оролдох болсноор ҮЭЧХ-ын дараа Алтайн хязгаарын асуудал хурцаджээ.

1912 оны 5-р сард Дундад Иргэн улсын шинэ ерөнхийлөгч Юань-Шикай засгийн газрынхаа хуралдаанд “Баруун Монгол” гэсэн засаг захиргааны шинэ нэгж байгуулах тухай хуулийн төслийг оруулан хэлэлцүүлжээ. Тэрхүү шинэ нэгжид Ховд болон Алтайн хязгаар ороод зогсохгүй Урианхайн хязгаар, Алашаа, Хөх нуур, Эзэн голын торгуудын нутаг дэвсгэрийг хамруулжээ.[5.65]

Энэ шийдвэрээ яаралтай хэрэгжүүлэхийн тулд мөн оны 6-р сард Бээжингийн засгийн газраас Ховд дахь манж-хятадын цэргийн хуаранд нэмэлт цэргийн хүчин илгээх шийдвэр гаргасан нь эндээс монголын нутгийн гүн уруу цөмрөх аюул учруулж болзошгүй хийгээд цэргийн хүчээр түрэмгийлэх нь илэрхий болов.

Энэ үед Богдын засгийн газраас Ховд хязгаарыг манж-хятадын дарлалаас чөлөөлөхийн тулд шийдвэртэй арга хэмжээ авсны үр дүнд Өрөмч, Шар сүмээс хятадын цэрэгт туслахаар ирсэн нэмэлт хүчийг ирэх замд нь дарснаас гадна 1912 оны 8-р сард Ховд хот, Ховдын хязгаарыг манж хятадын дарлалаас бүрмөсөн чөлөөлжээ. Энэ ялалт нь Ар монголоос Ховдын хязгаарыг таслан авах гэсэн Дундад Иргэн улсын санаархалд хүнд цохилт болжээ. Гэвч Хятадын засгийн газар Ховд, Алтайн хязгаарт анхаарлаа хандуулсаар байв.

Тэр үед хятадын төрийн томоохон түшмэдүүд Чэнь И, Ши Пин, Сюй Шүчжэн нар Ар монголоос ялангуяа Алтайн хязгаарыг таслан авах тухай саналыг засгийн газартаа олонтоо дэвшүүлж байв.

Чэнь И Алтайн 10 хошууг Шинжаанд харьяалуулах бодлогын тухай илтгэлдээ “Алтайг өмнө зүг Шинжаан, баруун Ил Гарвагатайтай амьсгал дуу чимээгээ эртнээс авалцах болсны гавьяа” хэмээн үнэлээд “Ганц мод тогтооход бэрхтэй тул тэр өнчин ганц модны үндсийг түшигтэй болгох аргыг бодох хэрэгтэй. Алтайн хязгаар нь алс хол ганцаараа байна. Засгийн газар нь ташуураа урт болгох боловч хүрэхгүй ядарч байна. Иймээс Алтайг Шинжаанд нийлүүлэх хэрэгтэй. Мянган ширхэг юмыг нэгэн ширхэг утсаар холбож буй мэт оршиж байгаа Алтайг ганцаар нь байлгаж болохгүй. Чэнь И миний бодоход нэгэн цагт түгшүүртэй явдал тохиолдвол заавал алдахад хүрнэ. Хожимдвол хэрхэн гэмшивч тус болохгүй.” [20.76] гэж засгийн газартаа яаралтай хэрэгжүүлэхийг сануулжээ.

Ши Пин нь 1913 оны 10 сараас 1918 оны 12 сар хүртэл Хул гэдэг газраас Булган, Чингэл, Шарбулаг, Хурт-ус, Шар сүмийн зэрэг

газруудаар явж орон нутгийн эдийн засгийн судалгаа явуулан энэ газруудыг харьяалах саяний /хошууны/ захиргаа байгуулахаар төлөвлөсний дотор энэдэх монгол нь тоогоор цөөн, мунхаг бүдүүлэг, хасгууд нь хэрцгий, хулгайч, ямагт хулгайлах, дээрэмдэх, алах дуртай [12.76] гэж дурджээ.

Мөн Ховдод сууж байсан Сую Шүчжэн Алтайн урианхай, торгууд нарын ноёд нь халхтай нэгдэхээр бичиг явуулсныг дурдан харамсаж, эцэст нь бороо орохоос урьд борооноос хамгаалах хэрэгтэй гэж [20.76] нууц утга бүхий Алтайн хязгаарын талаар нэн яаралтай арга хэмжээ авахыг санал болгосон бичгийг 1913 онд засгийн газартаа өргөжээ.

1912 оны намар хятадын төв засгийн газраас Шинжааны амбан Ян Цзэнсид шинэ цэргийг Ховд Алтайн чиглэлд илгээх тушаал ирснийг амбан ёсоор болгожээ. 1912 оны 12-р сард Бээжингийн тушаалаар Илийн хязгаараас их буу бүхий зэвсэглэсэн 1200 гаруй Дунгаан цэрэг Шар сүмд ирж байрлажээ. Мөн 1912 оны сүүлчээр Алтайн хязгаар дахь хятадын цэргийн гол хүчин нь 2000 хүний бүрэлдхүүнтэй Ховд Алтайн зааг Цагаан Түнгэ гэдэг газар байрлаж Ховдын зүг өдөөн хатгах болов.[5.67]

Алтайн хязгаарт Дунгаан цэргүүд орж ирсэн явдал болон тэдний өдөөн хатгалга нь Алтайн хязгаарын олон түмэнд нь хүндээр туссаны дээр Ховд, Улиастайд байнгын аюул занал учруулах болов. Хятад цэргүүд орон нутгийн иргэдийг тонон дээрэмдэж, зүй бус авирлах болов. Тэд удирдлага зохион байгуулалт сул, хоол хүнс, хангамж хүрэлцээгүй байснаас дотор нь үймээн гарч байв. Хятадууд ийнхүү цэрэг зэр зэвсгийн хүчээр сүрдүүлэхээс гадна 1912 оны 6-р сард хятадын ерөнхийлөгч Юань-Шикайн даалгавараар Алтайн хязгаарын захирагчаар томилогдон ирсэн Балт ван тус хязгаарын ноёд феодалыг өөрийн талд татах, ятгах оролдлогыг зүйл бүрээр явуулах болов. Тэрбээр хятадын талыг тууштай баримтлан, монголыг тэр дундаа Ховд, Алтайн хязгаарыг хятадын эрхшээлд ямагт байлгахыг улайран зүтгэж байлаа.

1912-1914 оны хооронд Балт нь Алтайн хязгаарын цэрэг, засаг захиргаа, иргэний байдал, хууль цааз, гадаад харилцаа зэрэг явдлыг ерөнхийлөн шийтгэх үүргийг гүйцэтгэж байв. Балт ван өөрийн эрх ямба сүр хүчийг ашиглан энэ хязгаар нутагт хятадын байр суурь, эрх ашгийг бататган бэхжүүлэхэд анхаарч алтайн урианхай, торгууд, хошууд нарыг айлган сүрдүүлэх, аргадан гуйхыг хослуулан эрхшээл

нөлөөндөө оруулахыг эрмэлзэж, тус хязгаарын монголчуудыг чангалан захирах болов.

Алтайн хязгаарын талаарх Монголын талын бодлого
үйл ажиллагаа

Олноо өргөгдсөн Монгол улс нь Алтайн хязгаарыг өөрийн газар нутгийн салшгүй хэсэг хэмээн үзэж, улс орныхоо газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангахын төлөө тэмцэх болжээ. Гэвч энэ тэмцэл нь хөрш хоёр гүрний эрх ашиг, тэр дундаа Дундад Иргэн улсын дипломат болон цэргийн үйл ажиллагаа, Монголын засгийн газрын бодлогын нөлөө зах хязгаар нутагт сул байснаас шалтгаалан төдийлөн үр дүн муутай байлаа.

Гэвч баруун хязгаарын байдал хурцалсан нөхцөлд 1913 онд Монголын засгийн газраас С.Магсаржавыг Улиастайгаас Ховдын хязгаарт явуулж халх, /Засагт хан, Сайн ноён хан аймгаас/ дөрвөд, тагна урианхайн зэрэг олон аймаг хошуудаас 4000 цэргийг дайчлан татуулж захируулан Гурван цэнхэрт суулгажээ.[2.12]Ховдын хязгаарын хошуудаас цэрэг татах ажлыг баруун хязгаарын олон монголчуудыг дагуулан тохинуулах цэргийг захирах сайдын хувьд Дамбийжанцан зохион байгуулжээ. Гэвч энэ цэргүүд нь даллага туршлага, хоол хүнс, унаа хөсөг зэвсэглэл муутай, ихэвчлэн орон нутгийн ард иргэдээс бүрдэж байсан учраас хятад цэргийн өмнө хүчин мөхөс байлаа. Ийм ч учраас Монголын засгийн газар Оросын талаас тусламж хүсэх болов.

1912 оны зун Богд Жибзундамба Ховдын хязгаарыг чөлөөлөхөд хаант Орос улсаас дипломат болон зэр зэвсгийн тусламж үзүүлсэнд талархалаа илэрхийлэхийн ялдамд Алтайн хязгаарыг чөлөөлөх үйлсэд мөн туслана гэдэгт итгэж байгаагаа илэрхийлжээ.[16.56] 1912 оны 12-р сар, 1913 оны 1-р сард Монголын засгийн газраас Оросын талд цэргээ Халх Ховд Алтайн хязгаарт оруулах бололцоо байгаа эсэх асуудлыг удаа дараа тавьж байжээ.

Алтайн хязгаарын талаарх Оросын хаант улсын бодлого үйл
ажиллагаа

ХИХ зууны сүүлчийн хагасаас хаант Орос улс Алтайн хязгаарыг сонирхох болж байр сууриа бэхжүүлэхийн тулд олон тооны худалдаачдыг оруулах болжээ. Мөн цаашид Алтайн хязгаарт улам бэхжихийн тулд 1912 онд Эрчис гол түүний урсгал болох Боржин голоор оросын онгоц аялан явах, мөн Боржин голын нийлэх аманд худалдааны газар байгуулах, Алтайд шуудан өртөө байгуулах эрхийг Алтайн хязгаарын захирагч Балтаас авчээ.

Мөн тэр үед хаант Орос улс Алтайн хязгаарт өмнө нь олсон байр сууриа хамгаалах, улам бэхжихийн тулд Ховд Алтайн хязгаарын талаар өөрийн бодлого барьж идэвхтэй оролцох болов. Оросын засгийн газар нь эхэн үедээ Ховд Алтайн хязгаарыг хятадын засаглалаас чөлөөлж, Халхад нэгтгэх явдлыг дэмжиж байжээ. [5.67] 1912 оны 6-р сард Оросын ГЯЯ-ны сайд С.Д Сазонов засгийн газартаа Халх Монголтой гэрээ хэлэлцээ хийх асуудлыг тавьж байв. Тэрбээр СнЗ-ийн дарга В.Н Коковцовт бичсэн захидалдаа удахгүй байгуулах гэрээний агуулгыг тусган Халх монголын бүрэлдхүүнд орвол зохих газар нутгийг тодорхойлон түүнд Ховд, Алтайн хязгаарыг оруулжээ. С.Д Сазонов Ховд, Алтайн хязгаарыг нэгтгэх нь “бидний ашиг сонирхолтой нийцнэ” гээд “газар зүй, эдийн засаг, угсаатны зүйн харилцааны хувьд тэр нь Халхын зүй ёсны үргэлжлэл” бөгөөд “хятадаас халхлах аятайхан халхавч болж” манай улсын хилтэй хил нийлдэг [5.67] гэжээ. Мөн С.Д Сазоновоос Бээжин дэх хаант оросын элчин В.Н Крупенскийд илгээсэн утсандаа “Алтайн хязгаарыг Халхтай нийлүүлбэл зүгээр юмсан, гэхдээ түүнд хүрэхэд ихээхэн бэрхшээлүүд байна” [5.70] гэжээ.

Мөн Шар сүмд суух хятад цэргүүд оросын харьяат иргэдийг дайсагнан айлган сүрдүүлэх, оросын худалдаачдаас авилгал авах, бараа таваарыг нь булаан авах зэргээр зүй бусаар харьцах болсноос гадна нэгэн дунгаан цэрэг Оросын консул Кузминскийн аминд халдахыг оролджээ. Ийм нөхцөлд Оросын талаас өөрийн консул болон харьяатуудын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг анхааруулан Алтайн хязгаараас дунгаан цэргүүдээ гаргахыг Оросын ГЯЯ-ны сайд С.Д. Сазонов Бээжин дэх Оросын консул В.Н Крупенскийгээр дамжуулан хятадын засгийн газарт шаардав. [5.71]

1913 оны 2-р сарын 25-нд Оросын СнЗ-д онцгой зөвлөлгөөн болж, Баруун монголд болж буй байдлыг тусгайлан хэлэлцээд, цэрэг дайны шинжтэй шийдвэр гаргажээ. Үүнд: Хүрээ, Улиастайгаас 4 пулемет, их буу бүхий казак цэргийн хороог Ховд уруу шилжүүлэх, Омскоос Обь мөрнөөр Ховдын хязгаар руу 2 батальон, 8 их буу, хагас суман сапёрчид, 50 гаруй казак цэрэг хөдөлгөхөд бэлэн байлгах, Зайсан хотоос Шар сүмд 2 пулемёт бүхий 2 суман цэргийг казак хэдэн зуун цэргийн хамтаар суулгах, Нийслэл хүрээнээс Ховд руу казак цэргүүд хөдөлмөгц түүний хойноос Иркутскийн цэргийн тойрогоос хоёр их буу, дөрвөн пулемёт бүхий батальон цэрэг илгээх [5.67-68] зэрэг байв.

Энэ шийдвэрийн дагуу Верхнеудинск /Улаан-Үд/ хотоос Да хүрээгээр дамжуулан Ховд хот хүртэл казак цэргийн ангийг явуулж,

мөн зун нь Бийскээс 3000 хүнтэй явган цэрэг, их бууны ангийг Ховдол ирүүлжээ.[6.98] Ховдол оросын цэргийн анги ирсэн нь хятадын цэргийн идэвхийг сулруулж, тэд Цагаан-Түнгээс цэргээ буцааж татахаас өөр аргагүй болгов.

Алтайн хязгаарт Оросын харьяат нар ба дунгаан цэргийн байдал хурцадсантай холбоотой 1913 оны 9-р сард хурандаа Сергеевын захирсан 500 гаруй хүнтэй нэг хороо цэргийг Шар сүмд суулгав. 1914 оны эхээр Алтайн хязгаар дахь Оросын отряд 4 их буу, 4 пулемёт бүхий 2 батальон явган цэрэг, 200 казак цэргүүдээс бүрдэх болов.

Цагаан түнгийн тулалдаан, “Гал зогсоох хэлэлцээр”
байгуулагдсан нь

Алтайн хязгаар нутаг нь Орос, Монгол, Хятад гурван улсын хил нийлэх чухал уулзвар газар болох тул тэнд их гүрнүүдийн эрх ашиг сонирхол хамгаас илүү огтолцон зөрөлдөж байсан юм.Тийм учраас энэ бүс нутгийн асуудал ихээхэн нарийн төвөгтэй байв.

Ялангуяа тус бүс нутагт хятад, монгол, орос цэргийн төвлөрөл үүсч, улмаар Алтай орчимд цэргийн томоохон мөргөлдөөн гарч болзошгүй болжээ.

1913 оны зуны эхээр Шинжаанаас нэрлэгдсэн хятад цэргийн дарга Май дайраны командалсан цэргийн отряд Ховдын Булганы нутагт шууд цөмрөн оржээ.[10.100] 1913 оны 6-р сарын 1-нд Цагаан-Түнгийн Улаан-Хайрхан гэдэг газар монгол, хятад цэргийн хооронд тулалдаан болж, монголын талаас 22 хүн алагдаж, 30 хүн шархтжээ.Мөн сарын 7-нд тэнд 2 удаа тулалдаан болж монголын талаас 700 гаруй цэрэг, хятадын талаас 2000 орчим цэрэг оролцож, хятадын 20 орчим цэрэг алагдаж, 50 морь олзлогджээ.[14.62-63] 7-р сарын 17-нд мөн хятадын 300 гаруй цэрэгтэй байлджээ.Энэ тулалдаануудад хятадын тал 300 гаруй цэрэг, 500 гаруй агт морио алджээ.[13.360] Нийслэл Хүрээнээс ирсэн монгол цэргүүд орон нутгийн ард олонтой хүч хавсран тэмцэж байлаа.Гэвч амжилт олохгүй байв.Энэ нь монгол цэргүүдийн зэвсэглэл, дадлага сургууль хангалтгүй, зах хязгаар нутагт Хүрээний засгийн бодлого үйл ажиллагаа төдий л хүрэхгүй, хүчтэй үйлчилж чадахгүй байсантай холбоотой.

Энэ байлдаан нь хэдэн сараар сунжирсан нь Ховд, Алтайн хязгаар дахь улс төрийн байдлыг тогтворгүй болгож, ард олны аж байдалд хүндээр тусч байв.

Ийм нөхцөлд хаант Оросын засгийн газраас буй болсон байдлыг зогсоохыг Хүрээн дэх консул А.Я Миллер, Шар сүм дэх консул М.Кузминский нарт даалгажээ. Түүний дагуу А.Я Миллерээс монголын эрх баригчдыг Алтайн хязгаарын асуудлаар буулт хийлгэхийн тулд ятгах, хавчих элдэв оролдлогыг хийжээ.[5.31]

Ийнхүү Оросын талаас байлдааны ажиллагаа цаашид даамжиран үргэлжилэхээс сэрэмжилж, түүний үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авч эхэлжээ. Алтайн хязгаарын захирагч амбан Балт ч энэ дайны үйл ажиллагааг зогсоохын төлөө байж, монголын талтай хэлэлцээ хийх зөвшөөрлийг Бээжингээс хүсэх болов.[15.57] Энэ байдлын тухай Балт төв засгийн газартаа илгээсэн цахилгаандаа тус хязгаарын хямралтай байдал, түүний хор уршгийн талаар өгүүлэхдээ “Алтай бол баруун хойдын дээд талд байдаг болоод Шинжааныг халхлан зүүн өмнөдийг батлах хязгаар орны үндсэн чухал газар болно...Хэрвээ Алтайг олбаас баруун хойд хамт оршиж, Алтайг алдбаас Дундад улс хамт мөхөх болно. Дээд жил Улиастай, Ховд өмнө хойноор алдагдаж, Алтай гадаад Монголд түрэмгийлэгдэн юуны түрүүнд цохигдож, эд мөнгө хоосорч, яах ч аргагүй хүчиртэй байдалд орлоо. Хэдэн удаа бодит хүчээр хамгаалснаас тэгээд аюулгүй болж чадав. Ойрд хөр цас хайлж, дөт зам салбарлан, халхын дээрэмчид (Б.Н монгол цэргүүдийг хэлсэн бололтой) хэдэн түмэн хүн дайчлан тусгайлан баруунши халдсанд бүх талаар бүслэгдэн хаагдаж, нэг орой хэдэн удаа цочин айж, гадаад улсын хүмүүс бас олон талаар өдөөлөг хийж, хязгаарын ард олон хоорондоо самуурч, цэргийн хүчин уядаж, цэрэг хүрэлцэхгүй байж, амуу будаа, өвс бордоо таслагдаж, аюултай байдалд орж, туйлын түгшүүртэй байна.”[13.360] гээд дайныг зогсоох хэлэлцээр хийхийг санал болгосонд Бээжингийн засгийн газар зөвшөөрчээ.

1913 оны 6-р сарын 29-нд Дундад Иргэн улсын ГЯЯ-наас В.Н Крупенскийд ирүүлсэн бичигтээ Хаант Орос, Дундад улс хоёр Монголын асуудлыг гүйцэд шийдтэл Шар сүм дэх Оросын консул М.Кузминский, амбан Балт нарын хооронд харилцан зөвшөөрөх хэлэлцээрийн төслийн болзлыг боловсруулах санал тавьжээ.[5.72] Энэ дагуу 8 сард Хятад, Орос улсын 2 талаас хамтран “Түр цагийн гэрээний эх ноорогийг нийт 6 зүйлээр тогтоон гаргажээ.

Үүний дараа Монгол, Шинжааны хооронд үүссэн байлдааны гал зогсоох хэлэлцээг Шар сүмд яаралтайгаар эхлүүлж, Монголын талын оролцоогүйгээр Шинжааны талыг торгуудын ван Балт, Хаант

Оросын талыг Кузминский төлөөлж хэлэлцэж, 1913 оны 12-р сарын 8-нд “Ховд Алтайн хоорондох монгол, хятад цэргийн дайны галын шугамыг газар дээр нь тогтоох Протокол”-д гарын үзэг зурав. Уг Протоколоор Монгол, Шинжааны хооронд байлдааны гал зогсоох шугамыг тогтоохдоо: Монгол Алтайн нуруугаар уруудаж, Алтайн нурууны Ганц модны даваанд хүрээд, Булган голын гольдирулоор уруудан өмнө зүг чиглэн Цагаан түнгэ, Туханцэг, Хараатын ам хүртэл шугамыг 8 сарын хугацаагаар тогтоожээ.[5.79] Мөн протоколоор 2 этгээдийн цэргийн суух газрыг заан тогтоож, 3 сарын дотор хятадын цэргийг Цагаан түнгэгээс гаргахаар болж, Оросын хаант улс Алтайн хязгаар дахь улс төр, эдийн засгийн өмнөх давуу байдлаа хадгалах болжээ. Энэ Протоколд хятадын талын шахалтаар өмнөх эх ноорог дахь Ховд, Алтайн хилийн зааг, урианхай, казах иргэн зэрэг дураараа шилжин нүүх, чөлөөтэй арилжаа наймаа хийх зэрэг зүйлийг хассаны хамт Протоколын 1-р зүйлд “Тус протокол бол зөвхөн хоёр этгээдийн цэрэг суух газрыг тогтоосон гэрээ болно. Ховд, Алтайн хилийн заагтай огт холбогдолгүй”[13.369] гэж тодорхой заан Ховд, Алтайн хилийн заагийг тогтоохоос зайлсхийжээ.

Энэ Протоколыг байгуулсан явдал нь Ховд Алтайн хязгаарын хил дээрх байлдааны үйл ажиллагааг зогсоож, энэ хязгаар нутагт улс төрийн хувьд тогтвортой байдал бий болгосноос гадна Монголын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалсан ач тустай үйл явдал болжээ.

Дундад Иргэн улс Алтайн хязгаарыг өөрийн захиргаанд
оруулсан нь

Хаант Орос улс эхэн үедээ Алтайн хязгаарыг хятадын дарлалаас чөлөөлж, Халхтай нэгтгэх бодлогыг дэмжиж байсан боловч яваандаа уг байр сууринаасаа татгалзснаас гадна Дундад Иргэн улсаас Алтайн хязгаарыг тасдан авах бодлогоо Оростой хамтран дипломат шахалтаар Монголоор хүлээн зөвшөөрүүлэх оролдлого хийх болжээ.

1913 оны 5-р сард Гадаад Монголын автономийг хүлээн зөвшөөрсөн тухай орос хятад хоёрын “Илэрхийлэн гаргах бичиг” гэгчийг гаргаж, түүнийгээ монгол ноёд феодалуудад далдуур ятах, тулгах ажил явуулсны эцэст 1913 оны 11-р сарын 23-нд “Оросоос Гадаад Монгол нь Хятад улсын нутаг дэвсгэрийн нэгэн хэсэг болохыг зөвшөөрөн хүлээсэн тухай мэдтүгэй” хэмээн солилцсон нот хавсралт бичгийг баталжээ. Нот бичгийн 4-р зүйлд “Ар монголын өөртөө засах газрын хязгаарын зүй нь урьдах Чин улсын Хүрээнд сууж хэрэг шийтгэх

сайд, Улиастайн жанжин, жич Ховдын хувийн сайдын захирсан хязгаараар хэмжээ болговоос зохимой. Гагцхүү одоо Монголын нарийн нягт газрын зураггүй бөгөөд харьяат олон газрын заагийг явуулах газрын хязгаар хэлхээг бас тодорхойлон хуваагаагүй тул Ар монголын зах хязгаарыг лавлан тогтоох ба Ховд, Алтайн хязгаарыг хуваах явдлыг зүй нь Илэрхийлэн гаргах бичгийн 5-р зүйлд бичсэн ёсоор хойш өдөр зөвлөн тогтоовоос зохимой” [14.101-102] гэжээ. Ийнхүү Ар монгол төдийгүй Ховд Алтайн хилийн заагийг тогтоохоос шууд зайлсхийсэн явдал нь цаашдаа эзлэн түрэмгийлэх, таслан авах бодлогоо хэрэгжүүлэхэд нээлттэй байлгах гэсэн хэрэг байлаа.

Ингээд Орос Хятад хоёр улс Монголын асуудлыг бүрэн шийдвэрлэж дуусахын тулд 1915 оны 5-р сарын 25-нд Хиагт хотноо Монголын талыг оролцуулан 3 улсын хэлэлцээр хийжээ. Гурван улсын хэлэлцээрээр Орос, хятадын “Илэрхийлэн гаргах бичиг” гэдгээ Монголд албан ёсоор хүлээлгэж, Ар монголыг ДИУ-ын харьяанд өөртөө засах “автономит” эрхтэй улс болгон үлдээжээ. Хиагтын хэлэлцээрийн 11-р зүйлийн ёсоор “Автономит Гадаад Монголын газар болбоос Дундад Иргэн улсын хоёрдугаар он арван нэгэн сарын 5, Орос улсын 1913 он октябрь сарын 23-ны өдөр Дундад, Орос хоёр улсын солилцсон нот бичгийн 4-р зүйлийн ёсоор урдахь-Хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд агсан газрууд бөгөөд Дундад улс лугаа нийлсэн хил болбоос зүүн зүг Хөлөн буйр, өмнө зүг Өвөр монгол, баруун өмнө зүг Шинэ хязгаар, баруун зүг Алтайн хязгаар лугаа хил нийлсэн Халхын дөрвөн аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр буй амой. Дундад улс, Автономит Гадаад Монголын хилийг чухам хуваах явдлыг Дундад, Орос хоёр улс Автономит Гадаад Монголын төлөөлөгчид тусгай хамт нийлэн шийтгэвээс зохих тул энэхүү гэрээг тогтоосноос хойш 2 жилийн дотор хамт нийлэн үүсгэн байцаамой” [18.15] гэж заасан юм. Энэ гэрээгээр Орос Хятад хоёр хуйвалдаж, монголын тусгаар тогтнолыг хязгаарлаж, хятад Оросын хооронд хоёр тийшээ эзэрхэгдэх автономит муж улсын шинжтэй болгож Монголын газар нутгийг таслан авсаны дотор Ховдын хязгаарын баруун захын Алтайн хязгаарын 10 хошууг монголоос албан ёсоор тасалжээ. Харин Алтай, Ховдын хил хязгаарыг хэрхэн тогтоох асуудлыг 2 жилийн дотор дахин хэлэлцэн тогтоохоор шийджээ.

Өмнө нь Ховд Алтайн хил хязгаарыг нарийн зааглаагүй явсаар ирсэн болон тодорхой газрын зураг үйлдэгдээгүй байснаас шалтгаалан 1917 оноос эхлэн Ховд Алтайн хил хязгаарыг тогтоох асуудал нь

Монгол, Хятадын аль алин эрх ашгийг хөндсөн ярвигтай асуудал болжээ. Энэ 2 хязгаар нутгийн хилийн заагийг тогтооход дараах бэрхшээлүүд оршиж байлаа. Үүнд

1/.Ховдын яаманд буй бүхий данс бичгүүд нь хар хулгана жилийн /1912 он/ хувьсгалын самуунд бүгдийг алдан гээгдүүлж, үлдсэн нь үгүй. Эдүгээ хэдүй олон зүйлийн бичиг зургууд буй боловч нарийн тодорхой үгүй. Алтайн яамны хошуудын данс бичгүүд нь мөн дутуу тул баримт гэрч болгож үл болмой. Энэ нь хянаж харьцуулахын бэрхтэй зүйл болно.

2/.Монгол, халхын бэлчээр нь ус, өвстэй газрыг дагаж суух учир суух нүүх нь тогтворгүй тул хутгаж самуурахад хялбар болно. Энэ нь бэлчээр хязгаарыг баримт болгож үл болох бэрх болно.

3/Ховд Алтайн хязгаар нь залгалдах бөгөөд гол нуруу үргэлжлэн уулын замууд дэгэлэн доголон, суух хүмүүс цөөхөн сийрэг, шавар ус замыг бөглөж, хавар өвөл болбоос цас мөс газар бүтээж, зам мөр ялгаварлан чадах үгүй. Энэ нь хязгаар нутгийн явдлыг бат нотоор байцаан тодорхойлоход бэрх [21.159] байв.

1917 оны 1-р сард Ховдын туслан шийтгэх тусгай түшмэл Сюй Чан Ши-гаас 3 улсын гэрээний 11-р зүйлд заасны дагуу Ховд Алтайн хил хязгаарыг яаралтай тогтоох саналыг засгийн газартаа мэдүүлжээ. Тэрбээр айлтгал бичигтээ Дундад улс, Монголын хил хязгаарыг зуран тогтоох хугацаа нь их ойртож байгаа учраас түүнд даруйхан бэлтгэхийг сануулж, "...Гадаад Монгол болбоос манай улсын орон нутгийн нэгэн хэсэг болох нь нэгэнт манай улсын харьяат нутаг болсон дор зүй нь хил хязгаар хэмээн хэлэх зүйл үгүй боловч гагцхүү бүрэн бүтэн засаг захиргааны газар ба өөртөөн засах газрууд нь нутаг орны дотор аяндаан ялгавартай зааг хэмжээ илэрхий тодорхойгоор тогтоож халдан эзлэх замыг бэхэлбээс зохих тул Иргэн улсын 2-р оны Дундад улсын илтгэлийн тусгай зүйлийн 4-р зүйл ба Дундад, Орос, Монголын гэрээний 11-р зүйлд тогтоосон бөлгөө. Энэ үеийн тогтоох хязгаар болбоос Алтай уул лугаа ойр шахах бөгөөд Шинжаан мужийн хязгаар лугаа залгагдах учир Алтайн дарга ба Шинжаан мужийн дарга нарт илгээн явуулж нэн даруйхнаа тодорхойлж хэрвээ бидний эрх хэмжээнд орох зүйл буй аваас тодорхой зургийг үйлдэж, гэрч баримтыг нь эрж олж бэлтгэл болговоос зохих мэт болмой. Нутаг оронд холбогдох учир дахин алгуурлан үл болох мэт" [21.130] гэж онцлон тэмдэглээд Ховд Алтайн хил хязгаарыг тогтооход анхааран баримтлах зүйл болон хил хязгаарын шугамын талаар өөрийн саналыг дурджээ. Ховд Алтайн хилийн заагийг тогтоох асуудал нэг мөр бололгүй хугацаа сунжирсаар байжээ.

Гэвч 1918 оны 8-р сард Хүрээний бүгдийг хамгаалах сайд Чэнь И Алтайн хязгаарыг Шинжаанд нэгтгэх тухай өргөх бичгийг Бээжинд явуулжээ.

Энэ дагуу 1919 оны 5-р сарын 16-нд /ДИУ-ын 8-р оны 6-р сарын 1/ Да цзүнтүнээс Чэнь И болон Алтай, Шинжааны захирагч, өөрийн олон яамдын санал хүсэлтийг үндэслэн “Эдүгээ гадаад эдийн засгийн, хуурай замын цэргийн, худалдаа, тариалангийн, монгол түвдийн зэрэг яамдуудаас Алтайн тусгай газрыг өөрчилж, нэгэн До-гийн газар болгох нэг хэргийг хамтран хянаад хавсаргах явдлыг биелүүлж, хязгаарын засалт дотор тус болгому”[21.165] хэмээн зарлиг гаргажээ. Энэ зарлиг ёсоор Алтайн хэрэг шийтгэх дарга, түшмэлийг татан буулгаж, түүний захирч байсан газрыг Шинжаан дор хавсаргаж нэгэн До-гийн газар болгожээ. Энэ үеэс хойш Алтайн хязгаар нь албан ёсоор Дундад Иргэн улсын Шинжаан мужийн бүрэлдхүүнд орж захирагдах болжээ. Энэ арга хэмжээний цаад зорилго, мөн чанар нь “Или, Тарвагатай, Алтайн гурван газрыг тэгш жагсааж, цөмийг Шинжааны гадаад халхавч болгох” [21.125] гэсэн Дундад Иргэн улсын төрийн алсын хараатай бодлоготой шууд холбоотой.

ИШЛЭЛ

1. Буурал тохойг сурвалж бичгүүдэд Бүрэн тохой, Булан тохой, Бор тохой гэж янз бүрээр тэмдэглэжээ. Энэ тохой нь Өлөнгөр нуурын зүүн өмнөд талын тохой бөгөөд эртнээс энэ хавийн оршин суугчид газар тариалан эрхэлж ирсэн юм.
2. Шар сүмийг хятадын түүх бичлэгт Циян-хуа-ши хэмээн бичжээ. Энэ нь одоогийн Шинжааны Алтайн аймгийн төв Алтай хот юм.
3. Дагаар орох гэсэн Алтайн хязгаарын эдгээр ноёд тайж нарын хүсэлтийг Богд эзэн өршөөж хишиг хүртээсэн тухай бичиг / 1912 / Баян-Өлгий аймаг дахь Орон нутаг судлах музейн үзмэрт буй.
4. Цагаан Түнгэ нь Ховд Алтайн хязгаарын хил дээрх стратегийн чухал төв бөгөөд түүгээр Улиастай, Ховд уруу өртөө зам дамжин өнгөрдөг байв.
5. До гэдэг нь Дундад Иргэн улсын мужийн доторхи засаг захиргааны нэгж юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Алтайн урианхайн 7 хошуу ба дөрвөдийн 2 гар, захчин, өөлд, мянгад хошууны нутаг захиргааны тухай хэрэг” Бадаргуулт төрийн 33-р он. УННС.ГБС
2. “Ардын Хатанбаатар Магсаржавын амьдрал үйл ажиллагаанд холбогдох баримт бичгүүд” УБ.1980
3. “БНМАУ-ын түүх” Дэд боть.УБ 1968.
4. Белов.Е.А Царская Россия и Западная Монголия в 1912-1915 годах.Проблемы Дальнего Востока. №1.М.1996
5. Белов.Е.А Россия и Монголия /1911-1919г/.М.1999
6. Бурдуков.А.В.Хуучин ба шинэ монголд.УБ.1987
7. Гангааням.С.Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь./1911-1921/УБ.1993
8. Гантулга.Ц.Алтайн урианхайн түүх, угсаа хамаадлын асуудал.УБ.1999.
9. Гонгор.Д Ховдын хураангуй түүх.ШУАХ.1964.
10. Даваасүрэн.Б, Мягмарсамбуу.Г Ардын Хатанбаатар С.Магсаржав УБ.1998
11. “Монголын сонин бичиг” Олноогийн 2-р он 8-р сарын 5 №5
12. Навааннамжил.Г. Өвгөн бичээчийн өгүүлэл.УБ.1956.
13. “Ойрад монголын товч түүх”.Доорд дэвтэр. Шинжааны ардын хэвлэлийн хороо.,2000
14. Пунцагноров.Ц.Монголын автономитын үеийн түүх УБ.1955
15. “Русско-китайские отношения:Официальные документы” (1689-1916).М.1958
16. Саруул.И ХХ зууны үеийн монголын нутаг дэвсгэр.УБ.1998
17. Санжмятав Б.Гурван улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үнэн УБ.1991.
18. Хорьдугаар зууны Монгол УБ.1995
19. Цэдэн-Иш.Б Төрөлх нутгийн төө газрын төлөө УБ. 1976
20. Цэдэн-Иш.Б. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс.УБ 1997
21. Чэнь-чунь-цзу. Гадаад монголын ойрхи үесийн түүх. Бээжин. Шанхай 1922. /Бадрахын орчуулга/. хятадаас орчуулсан нь УННС.гар бичмэл.
22. Яно. Монголын орчин жилийн түүх УННС.гар бичмэл.4 дэвтэр
23. Яно. Монголын урьдах үеийн түүх ба түүнийг шинжлэн үзсэн түүх. УННС. гар бичмэл.3 дэвтэр

СХЕМАТИЧЕСКАЯ КАРТА ВНЕШНЕЙ МОНГОЛИИ в 1911-1919 гг.

